



### Хувьцааны мэдээлэл

Ханш /2025.01.27/	519₮
Target price	575₮
Тикер	MSE:SBM
52 долоо хоног	452-584₮
Зах зээлийн үнэлгээ	392 тэрбум ₮
Нийт хувьцааны тоо	755,096,250
EPS	142
P/B	0.61
P/E	3.58

### Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



### Ханшийн хөдөлгөөн /2024.01-2025.01/



## "Төрийн Банк" ХК

Current price: 519₮

Target price: 575₮

### Компанийн тухай

Тус банк нь 2009 онд байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар Монгол Улсын 21 аймаг, 330 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэгт 500 гаруй салбар, тооцооны төвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2024 оны онцлох үйл явдлууд:

- ТОП – 100 ААН-ЭЭР шалгарав.
- Биржийн бус зах зээл дээр 10 тэрбум төгрөгийн ногоон бонд гаргав.
- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Төрийн банк тодорхой хэмжээний мод тарьж, байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулсан байна.

### Системийн 5 банкны төлөв байдал


"Төрийн Банк" ХК-ийн ROA (1.9%) болон ROE (17.8%) нь дундаж үзүүлэлтүүдээс (2.4%, 24.3%) доогуур байгаа нь банкны хөрөнгө, өмч ашиглалтын үр ашиг сул байгааг илтгэнэ. Мөн нийт хөрөнгө (6,218.5 тэрбум төгрөг) болон цэвэр ашиг (108.0 тэрбум төгрөг) нь бусад системийн банкуудтай харьцуулахад бага байгаа нь банкны цар хүрээ, ашигт ажиллагаа харьцангуй байгааг харуулж байна. Зах зээлийн үнэлгээний P/B үзүүлэлт 0.6 байгаа нь компанийн хувьцааны ханш зах зээл дээр хямд байгааг илэрхийлж байна.

	ROA	ROE	P/B	Нийт хөрөнгө*	Цэвэр ашиг*
Khan	3.2%	26.3%	0.9	20,302.7	638.5
GLMT	2.6%	32.1%	0.8	15,410.2	407.3
TDB	2.0%	20.3%	0.9	15,016.0	300.1
<b>SBM</b>	<b>1.9%</b>	<b>17.8%</b>	<b>0.6</b>	<b>6,218.5</b>	<b>108.0</b>
XAC	2.7%	25.6%	1.2	6,317.7	170.8
Дундаж	2.4%	24.3%	0.9	12,653.0	324.94


\*тэрбум ₮

## САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

### ROA, ROE /хувиар/



### Ашгийн үзүүлэлтүүд /тэрбум ₮, хувиар/



### Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүд



	2020	2021	2022	2023	2024
Зээл хадгаламжийн харьцаа	75.2%	102.3%	96.8%	107.2%	119.5%
Чанаргүй зээлийн хувь	10.8%	10.3%	12.3%	9.4%	5.7%

## АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /ROA, ROE/

2024 онд тус банкны нийт хөрөнгийн өгөөж өмнөх жилийн мөн үеэс 0.1 хувиар буурж 1.9 хувь гарсан ба уг бууралтын шалтгаан нь нийт хөрөнгийн өсөлт цэвэр ашгийн өсөлтөөс давсан нь гол нөлөөг үзүүлжээ.

Компанийн нийт өөрийн хөрөнгийн өгөөж 2024 онд өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өсөж 17.9 хувь болсон байна. Уг өсөлтөд цэвэр ашгийн өсөлт гол нөлөөг үзүүлсэн байна.

### Хүүгийн орлогын маржин

2024 оны эцсийн байдлаар тус үзүүлэлт нь 5.2 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2024 онд хүүгийн орлого 34 хувиар өссөн нь уг үзүүлэлтийн өсөлтийн шалтгаан болжээ.

### Цэвэр ашгийн маржин

Компанийн цэвэр ашиг нэмэгдсэн ч цэвэр ашгийн маржин 2024 онд 14.4 хувь байгаа буюу өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар буурчээ. Уг бууралтад харилцахад төлсөн хүүгийн зардал 111 хувиар, зээлийн хүүгийн зардал 179 хувиар өссөн болон Монголбанкны заавал байлгах нөөцийн хэмжээ 2 хувиар өссөн нь гол нөлөөг үзүүлжээ.

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны байдлаар нийт цэвэр зээл 3.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52.3 хувиар өссөн ба нийт хөрөнгийн 52.7 хувийг эзэлж байна. Хадгаламжийн хувьд өмнөх оны мөн үеэс 36.7 хувиар өсөж 2.9 их наяд төгрөг хүрсэн ба нийт өр төлбөрийн 51.3 хувийг, харилцахын хувьд өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар нэмэгдэж 1.4 их наяд төгрөгт хүрсэн ба нийт өр төлбөрийн 25.2 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн хувь 2024 оны байдлаар 5.7 хувь хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар буурсан нь банкны зээлийн эрсдэлийн удирдлага сайжирсанг харуулж байна.

### Зээл хадгаламжийн харьцаа

2024 оны байдлаар тус үзүүлэлт 119.5 хувь байгаа бөгөөд олон улсын туршлагаар уг үзүүлэлт 100 хувиас өндөр байвал зээл олголтын чанар, эргэн төлөлтийн эрсдэл өндөр байх магадлалтай ба банкны эрсдэлийг нэмэгдүүлж, төлбөрийн чадвар болон тогтвортой байдлыг бууруулдаг гэж үздэг. "Төрийн Банк" нь зээлийн эх үүсвэрийг төрөлжүүлж бусад санхүүгийн байгууллагуудаас татдаг болохийг уг үзүүлэлт харуулж байна.

## ДҮГНЭЛТ

2024 оны эцсийн байдлаар тус компанийн P/B харьцаа 0.61, P/E харьцаа 3.58 байна. Тус үзүүлэлт бага байгаа буюу компанийн хувьцаа зах зээл дээр бодит үнэ цэнээс бага үнэлэгдэж, ашигтай ажиллаж байгаа ч ханш хямд байгааг илтгэнэ. Компани нь банкны салбарын 9 хувийг дангаараа бүрдүүлж байна. Мөн "Төрийн Банк" ХК нь 2024 онд нийт 50 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон тараажээ.